

## Шилжих хөдөлгөөний өнөөгийн байдал

**Т.Навч**

*Хүн ам зүйн магистр,*

*МУИС-ийн ХАЗССТ-ийн багш*

Монгол улс зах зээлийн тогтолцоо руу шилжиж эхэлснээс хойш 10 гаруй жилийн хугацаанд нийгэм, эдийн засгийн шинэ шинэ өөрчлөлтүүд гарч улмаар тэдгээр нь тус улсын хүн амын оршин амьдрах ахуй нөхцөл, тэдний байршил, шилжих хөдөлгөөнд ч зүй ёсоор нөлөөлөх боллоо. Шилжих хөдөлгөөн нь хүн амын өсөлт, хөгжлийн асуудлын салшгүй бүрэлдэхүүн хэсэг бөгөөд тус улсын тогтвортой хөгжлийн олон чухал гогцоо асуудалтай логик холбоотой билээ.

Монгол улс хүн амын нягтралаараа дэлхийн хамгийн сийрэг орны тоонд багтдаг. Монгол улсын хүн ам 1918-2001 онд 648,1 мянгаас 2407,5 мянгад хүрч 3,7 дахин өсч хүн амын нягтралаараа 1918 онд 0,4 байснаа 2000 онд 1,5 болж өссөн байна. Гэвч энэхүү тоо нь улсын дундаж бөгөөд үүний цаана аймаг, сумдаар авч үзвэл харилцан адилгүй, тухайлбал, хамгийн нягтрал багатай аймагт Өмнөговь 0,3 хүн, хамгийн их нягтралтай нь Улаанбаатар хот тус тус орж байна.

Түүхэн үүднээс Монголд хүн ам харьцангуй цөөн, нутаг дэвсгэр уудам бөгөөд нүүдлийн иргэншил, бэлчээрийг шүтэх хэв шинж нь ерөөсөө хүн амын түр ба улирлын шинжтэй хөдөлгөөнийг зайлшгүй үзэгдэл мэт болгосон гэж хэлж болох юм.

Социалист тогтолцооны үеийн төлөвлөгөөт арга хэмжээнүүд нь хот сууринг олноор үүсгэх, сургуульд нийтийг хамруулах, аж ахуйн салбарыг байгуулах зэрэг арга хэмжээгээр дамжин суурин иргэншлийн хэв шинжид татагдах олон учир шалтгааныг бодит амьдрал ба хүмүүсийн сэтгэхүйд оруулж өгсөн билээ. Энэ нь үндсэндээ 70 гаруй жилийн түүхэн явц учраас уламжлалт шинж гэж үзэж болохоор байна. Үүний зэрэгцээ сүүлийн 10 жилд үүссэн нийгмийн тогтолцооны өөрчлөлт, зах зээл, эрх чөлөөт байдлын үр нөлөө нь өвөрмөц олон учир шалтгаанаар илрэн гарч хүн амын шилжилтэнд эерэг болон сөрөг олон үр дагавруудыг авчирч байна. Түүнчлэн 1992 онд батлагдсан шинэ үндсэн хуулинд "Монгол улсын иргэн оршин суух газар нутгаа чөлөөтэй сонгох эрхтэй" заасан заалт ч шилжих хөдөлгөөнд тодорхой хэмжээгээр нөлөөлж байгаа нь ойлгомжтой.

### Дотоод шилжих хөдөлгөөн

Манай улсад сүүлийн 40 гаруй жилд хотжилт мэдэгдэхүйц хурдацтай явагдсан юм. Одоо гэхдээ хотжих үйл явц бүс нутгаар жигд байж чадаагүй

бөгөөд Улаанбаатар, төмөр зам дагуу хот суурины цуваа бүрэлдэх чиглэлээр явагдсан гэж хэлж болно. Ялангуяа сүүлийн жилүүдэд Улаанбаатар хотод хүн амын бөөгнөрөл үүсээд байна. Одоогийн байдлаар манай улсын нийт хүн амын 57 хувь нь хот суурин газарт оршин сууж байгаа бөгөөд хотын хүн амын жилийн дундаж өсөлт нь хүн амын жилийн дундаж өсөлтөөс дээгүүр байна.

Хүн амын дотоод шилжих хөдөлгөөнд хөдөөнөөс хотод шилжин суурьших чиглэл давамгайлж байна. Аймгуудаас хотод шилжин ирэгсдийг хүн амын тоонд харьцуулан сүүлийн 10 жилийн дүнгээр авч үзэхэд 0,8-4,4 хувь болж байна. Аймгуудаас шилжин явагчдын 40 гаруй хувь нь баруун аймгийн иргэд байгаа бөгөөд хөдөөнөөс шилжиж ирэгсдийн 30 орчим хувь нь Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотод суурьшиж байна.

Хүн ам орон сууцны 2000 оны тооллогын дүнгээс харахад тооллого явагдахаас таван жилийн өмнө ямар нэгэн газар оршин сууж байсан 2127,5 мянган хүний 149,1 мянга нь Улаанбаатар хот болон бусад бүс нутгийн хооронд шилжих хөдөлгөөнд орсон гэсэн дүн гарчээ. Эдгээрийн 64,0 хувь буюу 95,4 мянган хүн Улаанбаатар хотод шилжин ирснээс үзэхэд хот руу шилжих хөдөлгөөн хир их байгааг харуулж байна. Түүнчлэн тооллогын дүнгээр нийслэлийн хүн амын 30 орчим хувь нь өөр газар төрсөн байв. Бүс нутгуудаас төвийн болон Улаанбаатар хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөн нь өөрийн гэсэн онцлогтой байна. Учир нь төвийн бүсэд шилжин ирэгчдийн хувьд тухайн газар нутаг шилжилтийн дамжлага үе шат болж байгаа бөгөөд тэдний шилжилтийн эцсийн үе шат нь Улаанбаатар байдаг ажээ.

Харин аймаг тус бүрээр сүүлийн нэг жилийн шилжих хөдөлгөөнийг авч үзэхэд Завхан, Увс, Говь-Алтай, Архангай, Баянхонгор, Хэнтий, Дундговь, Төв аймгууд шилжин явалт ихтэй, Дархан-Уул, Орхон, Улаанбаатарт шилжин ирэгчид их байна.

НҮБХАС-ийн санхүүгийн болон техникийн тусламжтайгаар Монгол улсын хүн амын байршил, шилжих хөдөлгөөнд нөлөөлж буй нийгэм, эдийн засгийн болон хүн амын хүчин зүйлсийг судлах зорилгоор "Хүн амын дотоод шилжих хөдөлгөөний микро түвшин судалгаа 2000<sup>1</sup>" хийгдэж үр дүн нь саяхан гараад байна. Энэ судалгаа нь Монгол улсын шилжих хөдөлгөөний талаарх мэдээлэл, судалгаа шинжилгээний ажил хангалтгүй байгаа өнөө үед шилжих хөдөлгөөнийг зохицуулах талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөр, бүс нутгийн хөгжлийн стратегийг боловсруулахад тодорхой хувь нэмрээ оруулах нь дамжиггүй.

<sup>1</sup> 2000 оны хүн ам, орон сууцны тооллого: "Үндсэн үр дүн", УСГ, 2001 он

## 1. Шилжих хөдөлгөөнд оролцогчид

Судалгааны дүнгээс харахад шилжигчдийн ихэнх хувь нь залуучууд, боловсролын түвшин багатай хүмүүс байв. Шилжилтийн хэлбэрийн хувьд гэр бүлийн шилжилт давамгайлж байна.

Шилжин ирэгчдийн дийлэнх хувь нь тооллогоос гарсан үр дүнтэй ижил баруун болон төвийн бүсийн аймгуудаас шилжин иржээ. Харин Дархан-Уул, Төв аймгуудын хувьд буцах шилжих хөдөлгөөн ихтэй байна.

Шилжин ирэгчдийн шилжих болсон гол шалтгаан нь ажил эрхлэх, зах зээлд ойртож амьдралын нөхцөл байдлаа сайжруулах, үр хүүхдийнхээ ирээдүйг бодох, төрөл саднаа бараадах явдал байсан ба эрэгтэйчүүд ажил эрхлэх шалтгаанаар илүү их шилжиж байхад эмэгтэйчүүд төрөл саднаа бараадах шалтгааны улмаас шилжсэн байна.

Шилжин ирэгчдийн шилжин ирсний дараах ажил эрхлэлтийн түвшин бусад төвлөрсөн газруудтай харьцуулахад Улаанбаатарт харьцангуй бага байна. Тухайлбал Дархан-Уул, Төв аймагт шилжин ирэгчдийн талаас илүү хувь нь нэг сарын дотор ажилд орсон байхад Улаанбаатарт шилжин ирэгчдийн хувьд энэ үзүүлэлт бага, харин хагас жилийн дотор ажилд орсон шилжин ирэгчдийн хувь өндөр байна. Гэвч шилжих хөдөлгөөнд оролцсоноор шилжин ирэгчдийн ахуй амьдралын нөхцөлд тодорхой хэмжээний өөрчлөлтүүд гарчээ. Тухайлбал, шилжиж ирсний дараа ерөнхийдөө ажлын байр, боловсрол, мэргэжлийн чадвар, хүүхдүүдийн сургалт, орон сууцны нөхцөл, зах зээл, орчин ахуй ба амьдралын ханамж, орлого, эрүүл мэнд сайжирсан байдал судалгаанаас ажиглагдлаа.

Гэвч нийслэлд шилжин ирэгчдийн хувьд шилжилттэй холбогдон багагүй бэрхшээлтэй асуудлууд тулгардаг болох нь судалгааны дүнгээс харагдлаа. Шилжин ирэгчдийн ойролцоогоор талаас бага хувь нь шилжин ирснээс хойш эрүүл мэндийн ямар нэг үйлчилгээнд хамрагдаж чадаагүй байна. Гэхдээ эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдаж чадаагүй гэж гарсан хүмүүсийн дийлэнх нь шилжин очсон газартаа бүртгүүлээгүй хүмүүс байна. Жич: Шилжин ирсний дараа оршин суугаа засаг захиргааны нэгждээ шилжин ирэгчдийн 73,5 хувь нь бүртгүүлжээ.

Судалгаанд хамрагдсан хүүхэдтэй бүх хариулагчдийн 71,2 хувь нь одоогийн байдлаар хүүхдүүддээ боловсрол эзэмшүүлэх боломжтой гэж үзэж байв. Харин хүүхдүүддээ боловсрол эзэмшүүлэх боломжгүй гэж хариулсан шилжигчдийн хувьд гол шалтгаанаа сургалтын төлбөр өндөр байгаатай холбон үзжээ.

## 2. Уугуул нутгийнхан

Дотоод шилжих хөдөлгөөн нэмэгдэж, цаашид нутаг эзгүйрэх аюул тулгарч байгаа өнөө үед уугуул нутгийн иргэдийн санал бодол, тэдэнд үзүүлж байгаа түлхэх хүчийг тодорхойлох зорилгоор шилжих хөдөлгөөн өндөр байгаа Архангай, Дундговь, Увс, Хэнтий аймгууд судалгаанд сонгогдсон юм

Судалгааны дүнгээс харахад уугуул нутгийнхний хувьд ажил олдохгүй, орлогын эх үүсвэргүй байх нь гол тулгарч буй бэрхшээл болж байна. Түүнчлэн уугуул иргэдийн олонхи нь хөдөө орон нутагт ажлын байр нэмэгдүүлэхийг Засгийн газраас хүсжээ. Мөн бүс нутгийг хөгжүүлэх, жижиг үйлдвэрлэлийг хөгжүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, цалинг цагт нь олгох, хуулийн хэрэгжилтийг дээшлүүлэх, хяналтыг сайжруулах, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах зэрэг арга хэмжээг хөдөө орон нутагт нэн яаралтай авахыг хүссэн байна. Үүнээс дүгнэлт хийхэд уугуул нутгийн иргэдэд үзүүлж байгаа түлхэх хүч нь дээрх шалтгаанууд гэж хэлж болохоор байна.

Уугуул нутгийн судалгаанд хамрагдсан хариулагчдын бараг гуравны нэг нь ирээдүйд шилжихийг хүсч байна. Үүнээс харахад хэрвээ шилжих хөдөлгөөний зохистой бодлогыг бодитойгоор амьдралд авч хэрэгжүүлэхгүй юм бол нутаг эзгүйрэх аюул улам бүр нэмэгдэж болзошгүй байна. Энд нэг анхаарал татаж байгаа зүйл бол ирээдүйд шилжихийг хүсэгчдийн ихэнх хувь нь 15-44 насны бүлгийн хүмүүс, шилжихийг хүсч буй гол шалтгаан нь зах зээлд ойртох, хүүхдүүдийнхээ ирээдүйг бодох, ажиллах гэсэн шалтгаанууд байгаа юм. Мөн тэдний дийлэнх нь нийслэл хот руу шилжих хүсэлтэй байгаа нь судалгааны дүнгээс харагдлаа.

### **Гадаад шилжих хөдөлгөөн**

Монгол улс нийгэм, эдийн засгийн тогтолцоогоо шинэчлэн харьцангуй нээлттэй болгосноос хойш 1990-ээд оноос эхлэн гадаад руу ажил хийх, суралцах зэрэг зорилгоор хүмүүс хууль ёсоор болон хууль бусаар / визийн зөвшөөрөлгүйгээр/ гарч ажиллах нь улам бүр нэмэгдэж байгаа билээ. Гэвч өнөөдөр гадаадад гарсан иргэдийн талаар албан ёсны мэдээлэл хараахан байхгүй учраас дэлхийн хэдэн оронд хичнээн хүн хууль ёсоор болон хууль бусаар амьдарч байгаа талаар нарийвчлан гаргасан бүрэн тоо мэдээлэл байхгүй байна. Гэвч олон тооны Монгол иргэд хууль бусаар гадаадад ажиллаж амьдарч, тодорхой хэмжээгээр мөнгөн гуйвуулга хийх замаар ар гэрийнхээ амьдралд нэмэр болж байгаа нь нууц биш юм. Харин эдгээр хүмүүстээ тухайн газарт амьдрах магадлал хир байгаа, өөрийн орны иргэний эрх зөрчигдөж байгаа эсэх, хаана хэдэн хүн байгаа талаар тодорхой мэдээлэл өнөөг хүртэл үгүйлэгдсээр байна. Энд

бүрэн бус мэдээллээс иш татахад 1995 оноос өмнө Монгол улсын төлбөрийн тэнцэлд гаднаас орж ирсэн хувийн гуйвуулгад ямарч утга бичигддэггүй байсан бол 1996 оноос эхлэн үндэсний нийт бүтээгдэхүүний тодорхой хувьтай тэнцэх хэмжээний валют орж ирэх болсон байна. Энэ үзүүлэлт 2000 онд 1996 оноос хоёр дахин нэмэгдсэн дүн гарчээ.

## Дүгнэлт

Шилжих хөдөлгөөний өнөөгийн байдлаас харахад Монгол улсын төрөөс баримтлах хүн ам зүйн бодлогод заасан заалтын хэрэгжилт хангалтгүй байгаа нь харагдаж байна. Ялангуяа засаг захиргаа, нутаг дэвсгэрийн зохистой тогтолцоо, нийгэм, соёлын үйлчилгээг хөдөөгийн хүн амд ойртуулснаар хот, хөдөөд жигд тархан суурьшуулах нөхцлийг бүрдүүлнэ гэж заасан заалт өнөөг хүртэл амьдралд хэрэгжихгүй байна. Түүнчлэн нийслэл болон томоохон хотын хүн амын хэт төвлөрлийг багасгах, дагуул хотууд бүс нутгийн төвүүдийг хөгжүүлнэ гэсэн заалтын хэрэгжилт ч хангалтгүй, ахиц гараагүй байна. Иймээс хүн амын шилжих хөдөлгөөнтэй холбогдсон ашиг сонирхол, зөрчлийг зөөлрүүлэх талаар уян хатан, алсын хараатай төрийн бодлого явуулахад шилжих хөдөлгөөнийг зохистой механизмаар залуурдах, арга, чиглэлийг нарийвчлан тодорхойлж өгсөн төрөөс баримтлах хүн амын бодлого өөрчлөн гаргах шаардлага амьдралаас урган гарч байна.

Жич: Судалгааны эх материалтай танилцахыг хүсвэл МУИС-ЭЗС-ийн Хүн Ам Зүйн Сургалт Судалгааны Төвд хандаж болно.